

СҮРЬЕЭТЭЙ

ӨВЧТӨНТЭЙ АЖИЛЛАХАД
ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ,
СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

ний
хөрхөн

Сүрьеэ бол
эдг
е

Сүрьеэ гэж
юу вэ?

Сүрьеэ нь
сүрьеэгийн нянгаар
үүсгэгддэг, голдуу
уушгийг гэмтээдэг
халдварт өвчин.



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Зохиогчид:

Энэхүү гарын авлагын 3 дахь хэвлэл нь Америкийн нэгдсэн улсын олон улсын хөгжлийн агентлагийн “Чанартай эрүүл мэндийн хамгаалал”-ын сүрьеэгийн төслийн бүсийн зөвлөх, Анагаах ухааны доктор Гомбогарамын Цогт, Анагаах ухааны доктор, Профессор Шахмурат Исмайлов, тус төслийн Казахстан дахь офиссын бүсийн техникийн захирал Бахтияр Бабамурадов, олон нийттэй тэмцэх үйл ажиллагааны зохицуулагч Елена Белова, төслийн менежер Елизавета Мыглина, сүрьеэгийн хөтөлбөрийн менежер Линара Ахмедзянова, ХДХВ-ын захирал Елена Кудусова нарын оролцоотойгоор нэмэлт хийгдэж шинэчлэгдсэн.

Орос хэлнээс орчуулсан: Б. Энхцэцэг, Анагаах ухааны магистр

Хянасан: Б. Амгалан, Нийгмийн эрүүл мэндийн магистр

Тус гарын авлагыг Азийн Хөгжлийн Банк болон Глобаль сангийн хамтарсан санхүүжилттэй Вируст гепатит, Сүрьеэгийн урьдчилан сэргийлэлт, илрүүлгийг сайжруулах Техник туслалцааны төслөөс хянан тохиож хэвлүүлээ.


Гарын авлагын сэдвүүд:

1. Сүрьеэ гэж юу вэ?
2. Сүрьеэ- эдгэрдэг өвчин
3. Сүрьеэ хэрхэн тархдаг вэ?
4. Халдвар авсны дараа хүний биед юу болдог вэ?
5. Сүрьеэ үүсэхэд юу нөлөөлдөг вэ?
6. Сүрьеэгийн үндсэн шинж тэмдэгүүд
7. Өвчний тархалтаас хэрхэн сэргийлэх вэ?
8. Хаана эмчилгээ хийдэг вэ?
9. Сүрьеэгийн эмчилгээг хэрхэн хийдэг вэ?
10. Яагаад эмийг шууд хяналттай уух ёстой вэ?
11. Хэрэв өвчтөн эмээ бүгдийг уухгүй, эсвэл эмчилгээгээ бүр мөсөн зогсоовол юу болох вэ?
12. Сүрьеэгийн эсрэг эмийн гаж нөлөө
13. Эмчилгээний үр дүнг хэрхэн хянаж болох вэ?
14. Сүрьеэгийн нян эмэнд тэсвэртэй болохоос хэрхэн сэргийлэх вэ?
15. Өвчтөний гэр бүл, ойр дотны хүмүүсийг сүрьеэгийн шинжилгээнд хамруулах шаардлагатай юу?
16. Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй аргууд байдаг уу?
17. Сүрьеэгийн эдгэрэлтийг хурдасгахад хоол хүнс, амралт ямар байх ёстой вэ?
18. Сүрьеэгийн эмчилгээнд архи, тамхи хэрхэн нөлөөлдөг вэ?
19. ХДХВ ба ДОХ-ын талаар юу мэдвэл зохих вэ?
20. Сүрьеэ ба ХДХВ хооронд ямар харилцан үйлчлэл байдаг вэ?
21. ХДХВ-тэй хүмүүсийг сүрьеэгээс урьдчилан сэргийлэх арга байдаг уу?
22. Сүрьеэтэй өвчтөний нийгмийн хамгааллын арга хэмжээнүүд
23. Сүрьеэтэй өвчтөний эрх
24. Сүрьеэтэй өвчтөний үүрэг
25. Сүрьеэтэй тэмцэхэд иргэн таны оруулах хувь нэмэр
26. Байнга асуудаг асуултууд

**ЭНЭХҮҮ гарын авлагыг
хэрхэн ашиглах вэ?**



Гарын авлагыг ашиглах зөвлөмж



Сүрьеэтэй өвчтөнтэй хийх мэдээлэл-сургалтын ажлыг хөнгөвчлөх зорилгоор тус гарын авлагыг бэлтгэв. Өвчтөний сонирхож буй сэдвээс хамаарч (жишээ нь сүрьеэ эдгэрдэг үү?) та хэрэгтэй хуудсыг нээгээрэй. Гарын авлагыг байрлуулахдаа зурагтай талыг өвчтөн харж байхаар, харин холбогдох зургийн тайлбар бичигтэй талыг өөр рүүгээ харуулаарай.

Эмнэлгийн ажилтнуудад зориулсан заавар

- Өвчтөнтэйгээ мэндлээд, түүний эмчилгээний тухай ярилцах гэж буйгаа тайлбарлаарай.
- Чимээгүй, гэрэлтэй, бас сайн агааржуулттай газрыг сонгож суугаарай
- Өвчтөнд гарын авлагын зураг харагдахаар байрлуулаарай.
- Ярилцлага хийхэд өвчтөнөө дэмжээрэй
- Хэрэв өвчтөнд асуух зүйл гарвал асуугаарай гэж хэлээрэй.
- Ярилцлагын сэдэв бүрийн дараа асуух асуулт байгааг лавлаж байгаарай.
- Ярилцлагынхаа төгсгөлд өвчтөнд дэмжлэгт нөөц байгаа талаар мэдээлэл өгөөрэй (өвчтөнг дэмжих бүлэг, дотрын эмч, урамшуулал болон хангамж үйлчилгээ гэх мэт)
- Цаг гарган хүрэлцэн ирсэн өвчтөндөө талархал илэрхийлж, үдэн гаргаарай.

Өвчтөнтэй хийх анхны уулзалтын ач холбогдол

Өвчтөн шинжилгээний хариу авахаар ирэх, эсвэл сүрьеэгийн эмчилгээг эхлүүлэх үед анх уулздаг. Өвчтөнтэй халуун дотно харилцаа тогтооход эхний уулзалт чухал ач холбогдолтой.

Анхны уулзалтаас л эмчилгээний туршид өрнөх цаашдын харилцаа шалтгаалдаг.

Эхний уулзалтыг амжилттай хийхийн тулд эмнэлгийн мэргэжилтэн:

- Ярилцлагын зорилгыг оновчтой тодорхойлох,
- Ярилцлагын сэдэв бүрт хангалттай хугацаа зарцуулахаар төлөвлөх,
- Өвчин болон эмчилгээний талаарх өвчтөний сэтгэл зовоож байгаа зүйлсийг сонсох.
- Өвчтөнтэй эмчилгээний зорилго, ашиг тусын талаар шаардлагатай бүх мэдээллийг хуваалцаж ярилцах хэрэгтэй.

Өвчтөнтэй харилцах бяцхан зөвлөмжүүд

Эмнэлгийн мэргэжилтэн өвчтөндөө шаардлагатай бүх мэдээллийг хүргэхэд тийм ч хялбар байдаггүй. Хүн дөнгөж өвчнийхээ оношийг мэдсэн үедээ сүрьеэгийн үүсгэгч юү болох, сүрьеэгийн эм, тэдгээрийн гаж нөлөө болон оношилгооны шинжилгээний талаар сонсоход бэлэн биш байж болно.

Өвчтөн өөрийнх нь хэрэгцээнд нийцсэн, амьдралын хэв маягийг нь өөрчлөхөөргүй мэдээллийг дуртайяа хүлээн авдаг.



Гарын авлагыг ашиглах зөвлөмж



Сүрьеэгийн талаар мэдээлэл өгөхийн өмнө өвчтөн юу мэдэж байгааг тодруулах хэрэгтэй. Тэд сүрьеэгийн талаар юу ч мэдэхгүй эсвэл бага зэрэг мэддэг, мэдэхгүйгээсээ санаа зовж, ичих юмуу төөрөлдөж байж болно. Эмнэлгийн мэргэжилтэн өвчний талаарх өвчтөний ойлголт нь үнэн зөв болохыг магадласан байх ёстой. Үүнд өвчтөнтэй хийх ярилцлагын сэдэв бүрийн өмнө тавих асуултууд нь эмчид тус болно. Өвчтөнийг ярилцлагаас цааргалуулахгүйн тулд болгоомжтой асуух хэрэгтэй.

Өвчтөнд тогтоолгохын тулд шинэ мэдээллийг олон дахин давтаарай. Ингэхдээ эмнэлгийн хэцүү нэр томъёонууд ашиглахаас зайлхийж, аль болох ойлгомжтой, энгийн үг хэллэг ашиглаарай. Хэт их мэдээлэл өгвөл өвчтөн юу ярьсныг тогтоохгүйгээс гадна айдас төрүүлж магадгүй. Тиймээс нэг удаагийн ярилцлагаар өгөх мэдээллийн хэмжээг хязгаарлах хэрэгтэй (гарын авлагын төгсгөлд “Дэглэмийг дагаж мөрдөхөд туслах аргууд” -г үзнэ үү).

Мэдээлэл-сургалтын ажилд өвчтөний эмчилгээний картыг ашиглах нь

Сүрьеэтэй өвчтөний эмчилгээний карт (ТБ 01 маягт) дээр өвчтөнтэй ярилцсан сэдвээ тэмдэглэ. Ингэхийн тулд картны (ар тал) сүүлчийн эгнээний нүдэнд буюу эм уусныг тэмдэглэдэг хэсэгт “Мэдээлэл-сургалтын ажил” гэж бичээд, дараа нь гарын авлагын сэдвийн дугаарт тохируулан “зөв” тэмдгээр тэмдэглэнэ. Ингэснээр та ярилцлагын сэдвийг дахин давтахгүй, эсвэл ямар нэгэн сэдвийг алгасалгүй хийхэд туслана.

Сэдвийн хэлбэр

Сар/өдөр	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31
Мэдээлэл-сургалтын ажил																															

Ихэнх хүмүүст өмнөх мэдээллийг давтаж, сануулах хэрэг гардаг тул дараагийн зөвлөгөөг “Өнгөрсөн удаад бид ярилцахдаа ...” гэсэн үгээр эхлэх хэрэгтэй. Тус гарын авлагын бүх сэдвээр өвчтөнтэй ярилцахыг хичээгээрэй. Өвчтөн эмчилгээгээ бүрэн дуусгах нь эмнэлгийн мэргэжилтний үзүүлэх тусламж хэр зэрэг оновчтой байхаас ихээхэн шалтгаална.

Өвчтөн эмчилгээний дэглэмийг дагаж мөрдөхийг ойлгуулахад туслах аргуудыг доорх хүснэгтэд үзүүллээ. Эдгээрийн зарим нь мэдээлэл-сургалтын ажилд тохиромжтой, зарим нь эмнэлгийн ажилтан өвчтөнтэй эерэг харилцаа үүсгэх, эмчилгээг үр дүнтэй болгоход тохиромжтой.

**Хэрэв Та эмчилгээний туршид
эмчийн зааврын дагуу эмээ
бүгдийг таслахгүй ууж
хэрэглэвэл ...**



**Харин эмчилгээгээ зогсоовол өвчин
улам хүндэрч, бусдад халдвар
тараах бөгөөд үхэж ч болно.**



**эрүүл энх, аз жаргалтай
байх болно!**



Эмчилгээний дэглэм сахих нь чухал гэдгийг өвчтөнд итгүүлж, ойлгуулахад туслах аргууд:



Өвчтөнтэй хийх үр дүнтэй ярилцлага :

- Өвчтөн бүрт хангалттай цаг зарцуулаарай
- Өвчтөндөө эргэлзээ төрүүлэлгүй чин сэтгэлээсээ яриарай
- Өвчтөнийхөө үнэ цэнэтэй зүйл болон итгэл үнэмшлийг ойлгож, авч үзэх
- Эмчилгээг, ялангуяа амбулаторийн эмчилгээг өвчтөний амьдралын хэв маягт тохируулахыг хичээгээрэй
- Нийгмийн халамжийн албатай холбоотой ажиллаарай
- Өвчтөнтэйгөө хүндэтгэлтэй ярилцаарай
- Өөрийнхээ үг, үйлдэл дээрээ хянамгай бай

Өвчтөнтэй хийх мэдээлэл-сургалтын ажил:

- Өвчтөнтэй анх уулзахдаа хамгийн чухал асуудлуудыг юун түрүүнд олж тогтоо
- Өвчтөнд өгөх мэдээллээ тодорхой, ойлгомжтой тайлбарла (өвчтөн оношоо сонсоод сэтгэл санаа нь түгшсэнээс болоод таны ярьсныг хүлээн авч чадахгүй байж болно)
- Амаар өгсөн зааварчилгааг бичгээр нэмэн өгөөрэй.
- Ярилцлагын эхнээс л эмчилгээний үргэлжлэх хугацааг шууд хэлээрэй
- Өвчтөнийг хэт их мэдээллээр бүү дар
- Энгийн, тодорхой ярь
- Өвчтөнд ойлгомжтой, хүртээмжтэй байх сургалтын материалыг ашигла
- Таны хэлсэн үгийг хэрхэн хүлээж авахыг ажигла
- Сүрьеэгийн талаарх өвчтөний мэдлэг, ойлголтыг үнэлж, эмчилгээний төлөвлөгөө гаргахдаа харгалзан үзээрэй.
- Сүрьеэ болон сүрьеэгийн эмчилгээний талаар өвчтөн юу мэддэг, юу гэж бодож байгааг сайн сонсож, ойлгохыг хичээгээрэй.
- Өвчтөн өвчнөөсөө айж байгааг харгалзан үзээрэй.
- Та өгсөн зааварчилгаагаа давтан өвчтөн зөв ойлгож байгааг нягтлаарай
- Өвчтөнөөс чухам юу шаардаж байгаагаа тайлбарлаарай.
- Өвчтөний асуултад товч, тодорхой хариулаарай

Эмчилгээ

- Өвчтөнд бүх зүйл ойлгомжтой байх хэрэгтэй (хуанли дахь тэмдэглэгээ, утасны дуудлага болон бусад)
- Хэрэв өвчтөн цагтаа ирээгүй бол түүнтэй шууд холбоо бариарай.
- Өвчтөнөөс эмийн гаж нөлөө гарсан эсэхийг асуугаарай.
- Эмийн гаж нөлөө гарсан бол энэ талаар тодорхой тайлбарлаарай.

Эрүүл мэндийн байгууллагын ажил

- Өвчтөнд тохь тухтай орчин бүрдүүлээрэй
- Эмнэлгийн ажилтан өвчтөнөө ойлгож, хүндэтгэлтэй харьцаж байгаа эсэхийг хянаарай.
- Эрүүл мэндийн байгууллагын ажлын зохион байгуулалт, эмчийн ажлын цагийн хуваарийг өвчтөний хэрэгцээнд нийцүүлэхийг хичээгээрэй.
- Эм тариа хүлээн авах, шинжилгээ өгөх, эрүүл мэндийн ажилтнуудтай харилцахад өвчтөнөөс илүү цаг хугацаа, хүч шаардахгүй байхад анхаараарай
- Ажилтнуудынхаа сэтгэл санааны байдлыг ажиглаж, шаардлагатай бол тэднийг сургах арга хэмжээ аваарай.
- Өвчтөнөөс авсан мэдээллийг задруулахгүй бай

Сүрьеэ гэж юу вэ?

Сүрьеэ нь
сүрьеэгийн нянгаар
үүсгэгддэг, голдуу
уушгийг гэмтээдэг
халдварт өвчин.



Сүрьеэ гэж юү вэ?

Сүрьеэ гэж
юү вэ?

Сүрьеэ нь
сүрьеэгийн нянгаар
үүсгэгддэг, голдуу
уушгийг гэмтээдэг
халдварт өвчин юм.



1

1.Зургийг үзүүлээд, “Та сүрьеэ өвчний талаар юу мэдэх вэ?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

“Сүрьеэ бол сүрьеэгийн нянгаар үүсгэгддэг, голдуу уушгийг гэмтээдэг халдварт өвчин юм. Энэ өвчний үед уушгинаас гадна бусад эрхтэн гэмтэж болдог. Уушги гэмтсэн үед өвчтөн цэртэй ханиалгаж, амьсгаадна. Сүрьеэ бүрэн эдгэрдэг өвчин. Гэхдээ эмчилгээ хийлгэхгүй бол үхэлд хүргэдэг аюултай.”

Сүрьеэ бол эдгэрдэг өвчин

**Хэрвээ эмчийн
зааврыг дагаж
мөрдөн, эмээ бүгдийг
уувал сүрьеэ бүрэн
эдгэрдэг.**



Сүрьеэ бол эдгэрдэг өвчин

**Сүрьеэ бол
эдгэрдэг
өвчин**

**Хэрвээ эмчийн
зааврыг дагаж
мөрдөн, эмээ бүгдийг
уувал сүрьеэ бүрэн
эдгэрдэг.**



1.Зургийг үзүүлээд, “Сүрьеэ бүрэн эдгэрдэг өвчин гэдгийг та мэдэх үү?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...



3. Тайлбарлаарай:

“Хэрэв эмчилгээг зөв хийж, дэглэмээ сайн баривал сүрьеэ 6-8 сарын хугацаанд бүрэн эдгэрнэ . Хамгийн чухал нь Та эмчилгээний бүхий л хугацаанд уувал зохих эмүүдийг таслалгүй бүгдийг уух хэрэгтэй. Сүрьеэгийн эмүүд бүгд үнэ төлбөргүй олгогддог. Эмчилгээг (амбулаторийн) ажил, амьдралын тогтсон хэв маягийг өөрчлөхгүйгээр хийх боломжтой ”

2

Сүрьеэ хэрхэн тархдаг вэ?


Уушгины хэлбэрийн сүрьеэтэй өвчтөн найтаах, ханиалгахад сүрьеэ тархдаг.



Сүрьеэ хэрхэн тархдаг вэ?

Сүрьеэ хэрхэн тархдаг вэ?

Уушгины хэлбэрийн сүрьеэтэй өвчтөн найтаах, ханиалгахад сүрьеэ тархдаг.



1.Зургийг үзүүлээд, “Сүрьеэ хэрхэн дамждагийг та мэдэх үү?” гэж асуугаарай:


2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

- “Сүрьеэгээр ямар ч хүн халдварлах боломжтой. Эмчилгээ хийлгээгүй уушгины сүрьеэтэй өвчтөн ханиалгах, найтаах, ярихад агаарт цацагдсан сүрьеэгийн нянгаар халдвар тархдаг .
- Эргэн тойрныхон энэ агаараар амьсгалснаар халдвар авах боломжтой. Иймээс хамгийн түрүүнд гэр бүлийн гишүүд (хавьтал гэж нэрлэдэг)-ийг шинжилгээнд хамруулах нь чухал.
- Сүрьеэ удамшдаггүй, ахуйн эд зүйлсээр дамждаггүй. ”

3

**Халдвар авсны
дараа хүний биед
юу болдог вэ?**



**Халдвар авсны дараа
биеийн эсэргүүцэл
сайн бол ихэнх хүмүүст
өвчин үүсдэггүй.**



Халдвар авсны дараа хүний биед юү болдог вэ?



1.Зургийг үзүүлээд “Сүрьеэгийн халдвар авсны дараа юү болдог вэ?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:


- “Халдвар авсны дараа ихэнх хүмүүсийн биед сүрьеэгийн нянг тойрон зузаан бүрхүүл үүссэнээр эрүүл эд эсээс тусгаарлагдан өвчин үүсдэггүй байна.
- Халдвар авсан хүмүүс нь өвчний эх уурхай болдоггүй, өөрөөр хэлбэл сүрьеэгээр халдварлагдах нь өвчилсөн гэсэн үг биш. Халдвар авсан хүмүүсийн 90-95 хувь нь хэзээ ч сүрьеэгээр өвчилдөггүй, үлдсэн 5-10 хувьд сүрьеэ өвчин үүсдэг байна.”

4

Сүрьеэ өвчин үүсэхэд юу нөлөөлдөг вэ?


Дараах зүйлсийн улмаас хүний
биеийн эсэргүүцэл (дархлаа)
сулардаг:

- ✓ ХДХВ-ийн халдвар, чихрийн
шижин зэрэг бусад өвчин
- ✓ Хоол тэжээлийн дутагдал
- ✓ Архидалт, мансууруулах бодист
донтох
- ✓ Стресс



Сүрьеэ өвчин үүсэхэд юү нөлөөлдөг вэ?

Сүрьеэ өвчин үүсэхэд юү нөлөөлдөг вэ?



Дараах зүйлсийн улмаас хүний биеийн эсэргүүцэл (дархлаа) сулардаг:

- ✓ ХДХВ-ийн халдвар, чихрийн шижин зэрэг бусад өвчин
- ✓ Хоол тэжээлийн дутагдал
- ✓ Архидалт, мансууруулах бодист донтох
- ✓ Стресс

1. Зургийг үзүүлээд, “Сүрьеэ өвчин үүсэхэд юү нөлөөлдөг гэж Та бодож байна вэ?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

- “Сүрьеэ өвчин үүсэх нь биеийн эсэргүүцэл сулрахтай холбоотой бөгөөд үүнд дараах зүйлс нөлөөлдөг:
 - ХДХВ-ийн халдвар, чихрийн шижин зэрэг бусад өвчин
 - Хоол тэжээлийн дутагдал
 - Архидалт, мансууруулах бодист донтох
 - Стресс”

5

Сүрьеэгийн үндсэн шинжүүд (шинж тэмдэгүүд):

**2 долоо хоногоос дээш
тасралтгүй цэртэй
ханиалгадаг.**

**Энэ нь гол төлөв биеийн
жин буурч турах,
халуурах, ядрах зэрэг
шинж тэмдэгтэй хамт
илэрдэг**



Сүрьеэгийн үндсэн шинжүүд (шинж тэмдэгүүд):

Сүрьеэгийн үндсэн шинжүүд (шинж тэмдэгүүд)

2 долоо хоногоос дээш тасралтгүй цэртэй ханиалгадаг.
Энэ нь гол төлөв биеийн жин буурч турах, халуурах, ядрах зэрэг шинж тэмдэгтэй хамт илэрдэг



6

1. Зургийг үзүүлээд, “Сүрьеэгийн ямар үндсэн шинж (шинж тэмдэгүүд)-үүдийг Та мэдэх вэ?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

“Өвчтөн сүрьеэгийн шинж тэмдэгүүдийг мэдэх нь хамт байсан хүмүүсээс сүрьеэтэйг ялган танихад хэрэгтэй.

2 долоо хоногоос дээш ханиалгах нь өвчин эхэлснийг илтгэх бөгөөд дор дурдсан нэг эсвэл хэд хэдэн шинж тэмдэгүүдтэй хамт илэрдэг:

- Турах (биеийн жин буурах)
- Халуурах
- Цээжээр өвдөх
- Хоолны дуршил буурах
- Ядрах
- Шөнө хөлрөх
- Амьсгаадах

Өвчний эхэн үед сүрьеэгийн шинж тэмдэгүүд янз бүр байдаг бөгөөд нэг дор зэрэг илрэх нь ховор. Иймд эдгээр шинж тэмдэгүүдээс аль нэг нь илрэх тохиолдолд эмчид хандах хэрэгтэй.”

Өвчний тархалтаас хэрхэн сэргийлэх вэ?

**Хэрэв та эмээ ууж,
ханиах, найтаахдаа ам
хамраа дарж хэвшвэл
бусад хүмүүст өвчин
тархах, халдварлахыг
бууруулж чадна.**



Өвчний тархалтаас хэрхэн сэргийлэх вэ?

Өвчний тархалтаас хэрхэн сэргийлэх вэ?

Хэрэв та эмээ ууж, ханиах, найтаахдаа ам хамраа дарж хэвшвэл бусад хүмүүст өвчин тархах, халдварлахыг бууруулж чадна.



7

1.Зургийг үзүүлээд “Сүрьеэгийн тархалтаас хэрхэн сэргийлж болохыг Та мэдэх үү?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

- “Эмчийн зааврын дагуу эмээ бүгдийг ууж, сүрьеэгээс бүрэн эдгэрснээр өөрийн дотны хүмүүс, найз, хамт ажилладаг нөхдөө өвчлөхөөс сэргийлнэ. Түүнчлэн өвчтөн :
 - Ам, хамраа хааж (амны хаалт зүүх) байх
 - Өрөө тасалгаагаа сайн агааржуулах хэрэгтэй.
- Энэ үед хоолны тусгай дэглэм сахих эсвэл сав суулга, бусад эд зүйлсийг халдваргүйжүүлж, ариутгах шаардлагагүй. ”

Хаана эмчилгээ хийгддэг вэ?

Сүрьеэг эмнэлэгт
(сүрьеэгийн тасагт),
эсхүл гэртээ
эмчилж болно.
Хаана эмчлүүлэх нь
илүү дээр болохыг
таны эмч шийднэ.



Хаана эмчилгээ хийдэг вэ?



8

1.Зургийг үзүүлээд, “Хаана эмчлүүлэх нь илүү дээр вэ?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

- “Эмчилгээг эмнэлэгт эсвэл гэрт хийхээс үл хамааран, сүрьеэг зөвхөн сүрьеэгийн эмээр л эмчилдэг. Эмчилгээний эхний 2 долоо хоногт халдвар тархах эрсдэл хурдан буурдаг.
- Хэрэв та амбулаториор эмчлүүлэх бол гэртээ байж, өөрийн хэвийн ажлын ихэнхийг үргэлжлүүлэн хийх боломжтой болно. Ингэснээр эмнэлэг дотор дамждаг тэсвэртэй хэлбэрийн сүрьеэгийн халдвар авах эрсдэлээс та зайлсхийж чадна. Амбулаториор эмчлүүлэхэд халдвар тараах эрсдэл буурдаг, учир нь өвчтөнтэй хамт нэг дор байсан хүмүүс онош тавихаас өмнө голдуу халдвар авсан байдаг.
- Өвчтөн эмээ авахаар өдөр болгон эмнэлэг хүрэхэд хүндрэлтэй, гэртээ шууд хяналтын дор өдөр тутмын эмийн тунгаа уух боломжгүй, эмчилгээний эхний 2 долоо хоногт гэр бүлийн гишүүддээ халдвар тараах эрсдэлийг бууруулахад чиглэсэн эмчийн зааврыг дагаж мөрдөх боломжгүй зэрэг тохиолдлуудад эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх нь тохиромжтой. Хэрэв амьдрах газаргүй бол эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхийг сонгоорой.”

Сүрьеэгийн эмчилгээг хэрхэн хийдэг вэ?

**Эмчилгээг эхний 2-3
сарын турш 4 эмээр
(эрчимт шат) хийдэг
бол дараагийн 4-6
сарын хугацаанд
2 эмээр хийдэг
(үргэлжлэх шат)**



Сүрьеэгийн эмчилгээг хэрхэн хийдэг вэ?

**Сүрьеэгийн
эмчилгээг хэрхэн
хийдэг вэ?**

Эмчилгээг эхний 2-3 сарын турш 4 эмээр (эрчимт шат) хийдэг бол дараагийн 4-6 сарын хугацаанд 2 эмээр хийдэг (үргэлжлэх шат)



9

1. Зургийг үзүүлээд, “Та сүрьеэгийн эмчилгээг хэрхэн хийдгийг мэдэх үү?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

- “Сүрьеэтэй өвчтөний эмчилгээ нь 2 шаттай. Нэгдүгээр – эрчимт шатанд өдөр бүр 4 эмийг 2-3 сарын турш уудаг. Энэхүү эмчилгээний үр дүнд сүрьеэгийн нянгууд хурдан устаж, өвчтөн ойр тойрныхондоо халдваргүй болж, нян эмэнд тэсвэртэй болохоос сэргийлдэг.
- Үргэлжлэх шатны эмчилгээнд 2 эмийг 4-5 сарын турш ууж хэрэглэдэг. Үүний үр дүнд өвчний гэмтсэн хэсэг эдгэж, өвчтөн эдгэрдэг.
- Эрчимт шатны эмчилгээг эмнэлэгт хэвтэж хийлгэсэн бол үргэлжлэх шатны эмчилгээг хэзээ, хаана хийлгэхийг тайлбарлаж өгөөрэй.”

Яагаад эмийг шууд хяналтын дор уух ёстой вэ?

**Өвчтөнүүд биеийн
байдлаа сайжрахын
хэрээр эмийг өнжиж
тасалдуулж эхэлдэг.
Иймээс бүх өвчтөнүүд
эмийг шууд хяналтын дор
уух шаардлагатай.**



Яагаад эмийг шууд хяналтын дор уух ёстой вэ?

Яагаад эмийг шууд хяналтын дор уух ёстой вэ?

Өвчтөнүүд биеийн байдлаа сайжрахын хэрээр эмийг өнжиж тасалдуулж эхэлдэг. Иймээс бүх өвчтөнүүд эмийг шууд хяналтын дор уух шаардлагатай.



1.Зургийг үзүүлээд, “Та юу гэж бодож байна, яагаад эмийг шууд хяналтын дор уух ёстой вэ?” гэж асуугаарай:

2.Хариултыг сонсоорой...

3.Тайлбарлаарай:



- “Эмчилгээний явцад өвчтөний биеийн байдал сайжрахад эмчилгээгээ тасалдуулах эрсдэл үүсдэг. Биеийн байдал сайжрах нь бүрэн эдгэрсэн гэсэн үг биш юм. Хэрэв өвчтөн эмнүүдээ бүгдийг уухгүй бол эдгэрэхийн оронд хайртай дотны хүмүүс, найз нөхөддөө халдвар тараах болно. Эмчилгээг завсарлах нь өвчнийг эдгэрэшгүй өвчин болгон хувиргадаг маш аюултай. Иймд бүх өвчтөний эмчилгээг заавал шууд хяналттай хийх шаардлагатай.

Шууд хяналттай эмчлүүлсэн сүрьеэтэй өвчтөнүүдийн 98 % нь эмчилгээгээ дуусгасан бол бие даан эмчилгээгээ хийсэн өвчтөний 11% нь л эмчилгээгээ гүйцээсэн болохыг судалгаагаар тогтоожээ. Эмчилгээ хийлгэхэд нь тусалж, эм уух цагийг сануулж, сэтгэл санаагаа хуваалцах хэн нэгэн таны дэргэд байна гэдэг бол хамгийн сайхан. ”

10

**Хэрэв өвчтөн эмээ бүгдийг
уухгүй, эсвэл эмчилгээгээ
бүрмөсөн зогсоовол юу
болох вэ?**

**Эмчилгээг
зогсоосноор
өвчтөн улам
хүндээр
өвчилж, бусдыг
халдварлуулахаас
гадна үхэж болно.**



Хэрэв өвчтөн эмээ бүгдийг уухгүй, эсвэл эмчилгээгээ бүрмөсөн зогсоовол юү болох вэ?



1.Зургийг үзүүлээд, “Хэрэв та эмнүүдээ бүрэн уухгүй, эсвэл эмчилгээгээ зогсоовол юү болно гэж бодож байна?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

- “Бүрэн эдгэрэхийн тулд эмчийн заалтын дагуу эмнүүдийг тогтмол, нэг дор уух хэрэгтэй. Эмийг бүгдийг уухгүй бол сүрьеэгийн нян эмэнд дасаж, улмаар өвчин үүсгэгчид нөлөө үзүүлж чадахгүйд хүрнэ. Үүний үр дүнд олон эмэнд дасалтай сүрьеэ (ОЭДС) үүсдэг бөгөөд эмчлэхэд 24 сар ба түүнээс дээш урт хугацаа шаардахаас гадна эмчлэхэд төвөгтэй байдаг.
- Эмчилгээг зогсоосноор өвчтөн улам хүндээр өвчилж, бусдыг халдварлуулахаас гадна үхэж ч болно.
- Өвчтөн эмчилгээний явцад оршин суух газраа өөрчлөх болбол эмчдээ урьдчилан мэдэгдэх ёстойг тайлбарлаарай. Эмнэлгийн ажилтан өвчтөний эмчилгээг үргэлжлүүлэх болон эмчилгээний үр дүнгийн талаар мэдээлэл авахын тулд өвчтөний шилжин очих орон нутгийн сүрьеэгийн эмчтэй холбоо тогтоодог.”

11

Сүрьеэгийн эмийн гаж нөлөө

**Сүрьеэгийн эмнүүд
бусад эмнүүдийн
нэгэн адил гаж нөлөө
үзүүлдэг. Энэ талаар эмч,
сувилагч нарт заавал
мэдэгдэх хэрэгтэй.**



Сүрьеэгийн эмийн гаж нөлөө

Сүрьеэгийн эмийн гаж нөлөө

Сүрьеэгийн эмнүүд бусад эмнүүдийн нэгэн адил гаж нөлөө үзүүлдэг. Энэ талаар эмч, сувилагч нарт заавал мэдэгдэх хэрэгтэй.



12

1.Зургийг үзүүлээд, “Та эмийн гаж нөлөө, тэр дундаа сүрьеэгийн эмийн гаж нөлөөний талаар мэдэх үү?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

- “Сүрьеэгийн эм нь бусад эмийн нэгэн адил гаж нөлөө үзүүлж болох бөгөөд энэ талаар та эмч, сувилагчдаа мэдэгдэх хэрэгтэй. Эмийн гаж нөлөө байнга тохиолддоггүй, голдуу дотор муухайрах, хоолны дуршил буурах, бага зэрэг толгой эргэх, үеэр өвдөх, шээсний өнгө улаан болох зэргээр хөнгөн хэлбэрээр илэрдэг. . Эдгээр нь сүрьеэгийн эмчилгээг зогсооход хүргэхээр тийм ч аюултай биш, аяндаа намждаг.
- Хүнд хэлбэрийн гаж нөлөөнд арьсны тууралт, арьсны шарлалт, сонсгол буурах, эсвэл хараа муудах зэрэг хамаардаг. Эдгээр гаж нөлөөний шинж танд илэрвэл нэн даруй эмчид, эсвэл сувилагчид мэдэгдэх хэрэгтэй. Энэ тохиолдолд эмчилгээнд өөрчлөлт оруулах шаардлага гарч болзошгүй”

Эмчилгээний үр дүнг хэрхэн хянаж болох вэ?

Эмчилгээний үр дүнг хэд
хэдэн удаагийн цэрний
шинжилгээгээр хянадаг.

Эмчилгээний явцад
өвчин үүсгэгч тууштай
алга болбол эмчилгээ үр
дүнтэй боллоо гэж үзнэ.



Эмчилгээний үр дүнг хэрхэн хянаж болох вэ?

Эмчилгээний үр дүнг хэрхэн хянаж болох вэ?

Эмчилгээний үр дүнг хэд хэдэн удаагийн цэрний шинжилгээгээр хянадаг.

Эмчилгээний явцад өвчин үүсгэгч тууштай алга болбол эмчилгээ үр дүнтэй боллоо гэж үзнэ.



1. Зургийг үзүүлээд, “Таны эмчилгээ хэр зэрэг үр дүнтэй хийгдэж байгааг мэдмээр байна уу?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

- “Эмчилгээний турш өвчтөн цэрээ хэд хэдэн удаа өгдөг бөгөөд үүнийг лабораторт шинжилнэ. Хэрэв сүрьеэгийн үүсгэгч цэрэнд илэрвэл, өвчин арай эдгэрээгүй байгааг илтгэнэ. Өвчин үүсгэгч илрээгүй бол өвчтөн эдгэрч байгааг илтгэх ч эмчилгээ хийгдэж дуустал урьдынхаараа эмээ үргэлжлүүлэн ууж дуусгах хэрэгтэй.
- Цэрийг хэзээ, хаана авах, цэрний шинжилгээний хариу эмчилгээнд хэрхэн нөлөөлөх талаар өвчтөнийг мэдээллээр хангасан байх хэрэгтэй.”

13

Сүрьеэгийн нянг эмэнд тэсвэртэй болохоос хэрхэн сэргийлэх вэ?

Эмэнд тэсвэртэй
хэлбэрийн сүрьеэ
үүсэхээс урьдчилан
сэргийлэх хамгийн
гол зүйл бол өвчтөнд
тохируулсан тунгаар
тогтоосон хугацаанд
эмнүүдийг ууж дуусгах
байдаг.



Сүрьеэгийн нянг эмэнд тэсвэртэй болохоос хэрхэн сэргийлэх вэ?

Сүрьеэгийн нянг эмэнд тэсвэртэй болохоос хэрхэн сэргийлэх вэ?

Эмэнд тэсвэртэй хэлбэрийн сүрьеэ үүсэхээс урьдчилан сэргийлэх хамгийн гол зүйл бол өвчтөнд тохируулсан тунгаар тогтоосон хугацаанд эмнүүдийг ууж дуусгах байдаг.



1. Зургийг үзүүлээд, “Эмэнд тэсвэржилт үүсэхээс хэрхэн сэргийлэх талаар Та мэдэх үү?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...


3. Тайлбарлаарай:

- “Сүрьеэгийн нян хүний биед удаан хадгалагддаг учраас өвчний шинж тэмдэг арилсан ч эмээ тасралтгүй ууж, эмчилгээг бүрэн дуусгах нь маш чухал. Эмчилгээ хэзээ бүрэн хийгдэж дуусахыг зөвхөн эмч л тодорхойлно.
- Сүрьеэгийн аль ч хэлбэрийн эмчилгээ үр дүнтэй болоход өвчтөн эмнэлгийн бүх зөвлөмжийг дагаж мөрдөх нь маш чухал.”

14

**Өвчтөний гэр
бүл, ойр дотны
хүмүүсийг сүрьеэгийн
шинжилгээнд хамруулах
шаардлагатай юу?**

**Тантай ойр хамт
байсан хэн ч танаас
сүрьеэгийн халдвар
аваагүй, сүрьеэгээр
өвдөөгүй гэдэгт
эргэлзээгүй болох
хэрэгтэй**



Өвчтөний гэр бүл, ойр дотны хүмүүсийг сүрьеэгийн шинжилгээнд хамруулах шаардлагатай юу?

Өвчтөний гэр бүл, ойр дотны хүмүүсийг сүрьеэгийн шинжилгээнд хамруулах шаардлагатай юу?

Тантай ойр хамт байсан хэн ч танаас сүрьеэгийн халдвар аваагүй, сүрьеэгээр өвдөөгүй гэдэгт эргэлзээгүй болох хэрэгтэй



1.Зургийг үзүүлээд, “Өвчтөний гэр бүл болон ойр дотны хүмүүсийг сүрьеэгийн шинжилгээнд хамруулах шаардлагатай юу?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

- “Шаардлагатай. Өвчтөнтэй ойр хамт байсан хэн боловч, ялангуяа нэг гэрт хамт амьдардаг хүн бүхэн оршин суугаа хаягийн дагуу эрүүл мэндийн байгууллагад очиж, шинжилгээнд хамрагдах ёстой.

Шинжилгээ нь өвчний шинж илрээгүй байхад ч өвчнийг хугацаа алдалгүй илрүүлэх боломж олгодог. Ингэх нь тааламжтай биш ч гэсэн тантай ойр байсан хүмүүсийн хэн нэгэн танаас халдвар авсан эсэхийг шалгах нь чухал. Шинжилгээ хийх явцад тэдэнд сүрьеэ илэрвэл сүрьеэгийн бүрэн эмчилгээг хийнэ.

- Өвчтөнтэй ойр байсан тав хүртэлх насны хүүхдүүдийг сүрьеэгээр өвчлөхөөс сэргийлж, эмийн урьдчилан сэргийлэлтэд хамруулдаг.”

15

Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй аргууд байдаг уу?

Сүрьеэтэй өвчтөнийг эмчлэх нь сүрьеэгийн халдвар тархахаас сэргийлэх хамгийн чухал арга, учир нь түүнийг халдварын эх уурхай байхыг болиулж чаддаг. Урьдчилан сэргийлэх бусад арга нь нярай хүүхдийг дархлаажуулах, өрөө тасалгааг агааржуулах, "ханиах үеийн эрүүл ахуйн дэглэм"ийг сахих явдал юм.



Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй аргууд байдаг уу?

Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй аргууд байдаг уу?

Сүрьеэтэй өвчтөнийг эмчлэх нь сүрьеэгийн халдвар тархахаас сэргийлэх хамгийн чухал арга, учир нь түүнийг халдварын эх уурхай байхыг болиулж чаддаг. Урьдчилан сэргийлэх бусад арга нь нярай хүүхдийг дархлаажуулах, өрөө тасалгааг агааржуулах, “ханиах үеийн эрүүл ахуйн дэглэм”-ийг сахих явдал юм.



1.Зургийг үзүүлээд, “Та сүрьеэгээс сэргийлэх аргын талаар сонсож байсан уу, эсвэл ямар нэгэн арга мэддэг үү?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

- “Сүрьеэтэй өвчтөн эмчилгээ хийлгээгүй бол сүрьеэгийн халдварыг тараах эх уурхай байдаг. Иймээс сүрьеэтэй өвчтөнийг илрүүлж, эмчлэх нь сүрьеэгээс урьдчилан сэргийлэх хамгийн чухал арга юм.
- Урьдчилан сэргийлэх бусад үр дүнтэй аргууд нь :
 - Нярайн дархлаажуулалт/вакцинжуулалт. Хүүхдийг төрөх үед нь сүрьеэгийн эсрэг БЦЖ вакцин хийснээр хүүхдийн амь насанд аюултай, хүнд хэлбэрийн сүрьеэ үүсэхээс сэргийлдэг.
 - Өрөө, тасалгааг тогтмол агааржуулах
 - “Ханиах үеийн эрүүл ахуйн дэглэм”-ийг сахих, өөрөөр хэлбэл ханиах, найтаахдаа алчуур (салфеток)-аар амаа дарах хэрэгтэй
 - Ахуйн хэрэгслийг хэрэглэсний дараа халдваргүйжүүлж байх
 - Эрүүл амьдралын хэв маягтай байх.”

16

**Сүрьеэгийн эдгэрэлтийг
хурдасгахад хоол хүнс
ямар байх ёстой вэ?**

**Хоол хүнс нь жимс,
ногоо, мах, будаа,
үр тариа зэрэг
олон төрлийн
амин дэмээр
баялаг, тэжээллэг,
зохистой байх
ёстой.**



Сүрьеэгийн эдгэрэлтийг хурдасгахад хоол хүнс, амралт ямар байх ёстой вэ?



1.Зургийг үзүүлээд “Сүрьеэгийн эдгэрэлтийг хурдасгахад хоол хүнс ямар байх ёстойг та мэдэх үү?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...


3. Тайлбарлаарай:

- Ямар нэгэн тусгай хоолны дэглэм барих шаардлагагүй.
- Хоол тэжээл нь жимс, ногоо, мах, будаа, үр тариа зэрэг олон төрлийн амин дэмээр баялаг, тэжээллэг, зохистой байх хэрэгтэй.
- Зохистой хоол хүнс нь хүний биеийн дархлааг сайжруулж, эмийн шингэлтийг хялбар болгодог. Энэ зорилгоор айраг, цагаан идээ гэх мэт ардын уламжлалт идээ ундыг хэрэглэж болно. Гэхдээ эдгээр нь сүрьеэгийн нянг устгахгүй учраас сүрьеэг эмчлэх арга биш юм .
- Бүтэн нойр (өдөрт 8-10 цаг), амралт, эрүүл агаарт байх нь эдгэрэлтэд сайнаар нөлөөлдөг .”

17


**Сүрьеэгийн эмчилгээнд
архи, тамхи хэрхэн
нөлөөлдөг вэ?**

**Архи, тамхи хэрэглэх
нь өвчний явцыг
улам даамжруулж,
сүрьеэгийн
эдгэрэлтийг
удаашруулдаг.**



Сүрьеэгийн эмчилгээнд архи, тамхи хэрхэн нөлөөлдөг вэ?

Сүрьеэгийн эмчилгээнд
архи, тамхи хэрхэн
нөлөөлдөг вэ?



Архи, тамхи хэрэглэх нь өвчний явцыг улам даамжруулж, сүрьеэгийн эдгэрэлтийг удаашруулдаг.

1.Зургийг үзүүлээд, “Сүрьеэгийн эмчилгээнд архи, тамхи хэрхэн нөлөөлдөг вэ?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

- “Архи уух нь элэгний үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг. Архи болон эмийг нэг дор зэрэг хэрэглэвэл элгэнд нөлөөлөх хоруу чанар ихэсч, элэгний үйл ажиллагаанд өөрчлөлт оруулдаг байна. Үүний үр дүнд эмийн гаж нөлөө үүсэх эрсдэл нэмэгдэнэ.
- Тамхи эрүүл уушгины ажиллагаанд ч муугаар нөлөөлдөг. Иймээс уушги сүрьеэгээр гэмтсэн байхад тамхи татах нь уушигны ажиллагааг улам муутгаж сулруулдаг. Энэ байдлаар архи, тамхи хэрэглэх нь өвчний явцыг хүндрүүлж, сүрьеэгийн эдгэрэлтийг удаашруулдаг байна. Гэхдээ сонголтыг та л хийнэ ”

18

ХДХВ ба ДОХ-ын талаар юу мэдвэл зохих вэ?

**ДОХ нь гар барих,
үнсэлцэх, шавж хорхой
хазах болон хувцас, ор
дэрний даавуу, хоол
хүнс, сав суулга, шүлс,
салсаар дамждаггүй.**



ХДХВ ба ДОХ-ын талаар юу мэдвэл зохих вэ?

ХДХВ ба ДОХ-ын талаар
юу мэдвэл зохих вэ?

???

Д О Х



ДОХ нь гар барих,
үнсэлцэх, шавж хорхой
хазах болон хувцас, ор
дэрний даавуу, хоол
хүнс, сав суулга, шүлс,
салсаар дамждаггүй.



19

1.Зургийг үзүүлээд “ХДХВ ба ДОХ-ын талаар юу мэдвэл зохих вэ?” гэж асуугаарай:


2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

- “ХДХВ (хүний дархлаал хомсдлын вирус) нь хүний дархлааны тогтолцоог дарангуйлж, хэсэг хугацаанд илрэхгүй байж болно .
- ХДХВ нь а/ ХДХВ-ийн халдвартай хүнтэй хамгаалалтгүй (бэлгэвчгүй) бэлгийн хавьталд орох, б/ мансууруулах бодисыг бэлтгэх, хэрэглэхдээ ариутгаагүй сав, тариур, зүү болон бусад зүйл хэрэглэх, в/ ХДХВ-ын халдвартай цус юүлэх, г/ халдвар авсан эхээс жирэмсэн, төрөлт болон хөхүүл үед хүүхдэд дамжин халдварладаг.
- ХДХ-ын вирус нь цус, үрийн шингэн , үтрээний шүүрэл болон хөхний сүүнд халдвар тараахуйцаар хангалттай хэмжээтэй байдаг .
- ХДХВ нь гар барих, үнсэлцэх, хорхой шавж хазах, ор дэрний даавуу, хувцас, хоол хүнс, сав суулга, шүлс, салсаар дамжихгүй.
- ДОХ (дархлаалын олдмол хомсдол) нь ХДХВ-ийн халдварын сүүлийн шат бөгөөд дархлааны тогтолцооны үйл ажиллагааны өөрчлөлт болон эмнэлзүйн янз бүрийн шинж тэмдэгүүдээр илэрдэг.
- ХДХВ-г илрүүлэхийн тулд цусны шинжилгээ өгөх хэрэгтэй (сорил). Сорил нь үнэ төлбөргүй хийгдэнэ.
- ХДХВ-ээс хамгаалах арга: а/ халдваргүй найдвартай ганц бэлгийн хавьтагчтай байх, б/ бэлгийн хавьтал бүрт чанартай бэлгэвчийг , зөв хэрэглэх, в/ нэг удаагийн зүү, тариур хэрэглэх.”

**ХДХВ ба сүрьеэгийн
хооронд ямар харилцан
үйлчлэл байдаг вэ?**

**ХДХВ-ийн
халдвартай
хүмүүс сүрьеэгээр
халдварлагдаж,
өвчлөх нь илүү
байдаг.**



ХДХВ ба сүрьеэгийн хооронд ямар харилцан үйлчлэл байдаг вэ?



1. Зураг үзүүлж “ХДХВ ба сүрьеэгийн хооронд ямар харилцан үйлчлэл байдаг вэ?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

- “ХДХВ-ийн халдвартай хүмүүс сүрьеэгийн халдвар авах, сүрьеэгээр өвдөх хандлагатай байдаг. Сүрьеэ нь ХДХВ-ийн халдварын явцыг хүндрүүлдэг онцлогтой. ДЭМБ-ын мэдээллээр сүрьеэгийн идэвхитэй хэлбэрээр өвчлөх эрсдэл ХДХВ-ийн халдваргүй хүмүүсээс ХДХВ-тэй хүмүүсийн дунд 20-30 дахин их байдаг байна.
- Дархлал хомсдолын вирусийн нөлөөгөөр хүний дархлаа суларч, янз бүрийн халдварт өвчин ялангуяа сүрьеэгийн халдварт өртөмтгий болдог. Хэрэв тэрээр өмнө нь сүрьеэгийн нянгаар халдварлагдсан бол суларсан дархлааны суурин дээр сүрьеэгээр өвдөх эрсдэл нэмэгдэнэ. ХДХВ-тэй 4 хүн тутмын нас баралтын шалтгаан нь сүрьеэ болдог. Тиймээс сүрьеэ илэрвэл ХДХВ-ийн сорил хийлгэх хэрэгтэй.
- Сүрьеэтэй бүх өвчтөнд ХДХВ-г илрүүлэх шинжилгээг хийдэг.”

20

Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх аргууд байдаг уу?

**ХДХВ-тэй хүмүүст
сүрьеэгийн урьдчилан
сэргийлэлтийг 6 сарын
турш изониазидаар
хийдэг.**



ХДХВ-тэй хүмүүсийг сүрьеэгээс урьдчилан сэргийлэх арга байдаг уу?

Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх аргууд байдаг уу?

ХДХВ-тэй хүмүүст сүрьеэгийн урьдчилан сэргийлэлтийг 6 сарын турш изониазидаар хийдэг.



1. Зураг үзүүлж “ХДХВ-тэй хүмүүсийг сүрьеэгээс урьдчилан сэргийлэх арга байдгийг Та мэдэх үү?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

- “Сүрьеэгийн эмч ХДХВ-тэй хүнд идэвхитэй хэлбэрийн сүрьеэг үгүйсгэсний дараа изониазид 6 сарын турш уулгаж сүрьеэгээс урьдчилан сэргийлдэг. ДОХ-ын төвд халдвартын эмч химийн урьдчилан сэргийлэлтийг хийдэг.

Үүний зэрэгцээ ретровирусний эсрэг эмчилгээнд ХДХВ-тай хүмүүсийг хамруулах нь дархлааны тогтолцоог сайжруулдаг тул сүрьеэгийн халдвар авах эрсдэлийг бууруулдаг.”

21

Сүрьеэтэй өвчтөний нийгмийн хамгааллын арга хэмжээнүүд

- Өвчтэй байх хугацаанд эмнэлгийн хуудсаар тэтгэмж олгоно (ажил, хөдөлмөр эрхлэгчдэд)
- Өвчтэй байх хугацаанд ажлын байрыг нь хадгалдаг.
- Бүрэн эдгэрэх хүртэл урт хугацааны эмчилгээ хийгдэх тохиолдолд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоож группд оруулна
- Өвчтөнд нийгмийн дэмжлэг туслалцааг ямар нэгэн байдлаар үзүүлнэ (орон нутгийн засаг захиргааны байгууллагаас)



Сүрьеэтэй өвчтөний нийгмийн хамгааллын арга хэмжээнүүд



1.Зургийг үзүүлээд, “Сүрьеэтэй өвчтөний нийгмийн хамгааллын ямар арга хэмжээнүүдийг мэдэх вэ?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

- “Төр засаг өвчтөнг бүрэн эдгэрэх боломжоор хангадаг.
- Сүрьеэгийн улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан иргэдийн ажлын байр хууль тогтоомжид заасны дагуу хадгалагдаж байдаг
- Сүрьеэтэй өвчтөнийг түр ажиллахгүй байх хугацаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу улсаас нийгмийн даатгалын тэтгэмж олгодог
- Өвчтөнүүд эмчилгээний турш сүрьеэгийн эмээр үнэ төлбөргүй хангуулах эрхтэй. “


22

Сүрьеэтэй өвчтөний эрх

- Сүрьеэгийн үед эмнэлгийн тусламж, үйлчилгээг үнэ төлбөргүй авах

- Хүндэтгэлтэй харьцаа , нэр төрөө хамгаалуулах эрхтэй


- Сүрьеэтэй өвчтөнд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээлэл авах эрхтэй



Сүрьеэтэй өвчтөний эрх

Сүрьеэтэй өвчтөний эрх

- Сүрьеэгийн үед эмнэлгийн тусламж, үйлчилгээг үнэ төлбөргүй авах
- Хүндэтгэлтэй харьцаа, нэр төрөө хамгаалуулах эрхтэй
- Сүрьеэтэй өвчтөнд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээлэл авах эрхтэй



1. Зураг үзүүлж “Та сүрьеэтэй өвчтөний эрхийн талаар мэдэх үү?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

“Сүрьеэтэй өвчтөн дараах эрхтэй:

- ”Сүрьеэгийн онош тавигдсанаас эмчилгээ хийж дуусах хүртэл хугацаанд үнэ төлбөргүй, хүртээмжтэй эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхтэй
- Эмнэлгийн ажилтнуудын зүгээс ямар нэгэн ялгаварлан гадуурхсан, болгоомжилсон харьцаа хандлагыг зөвшөөрөхгүй бөгөөд хүндэтгэлтэй, зохистой харьцаа авах эрхтэй,

Сүрьеэтэй өвчтөнд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ, өвчтөний эрх, үүрэг, сүрьеэгийн эмчилгээнд шаардагдах шууд болон шууд бус зардлын талаар мэдээлэл авах эрхтэй

23

Сүрьеэтэй өвчтөний үүрэг

- Эрүүл мэндийнхээ тухай эмнэлгийн мэргэжилтэнд мэдээлэл өгөх үүрэгтэй
- Өвчтөнтэй ойр байсан гэр бүлийн гишүүд, ойр дотны болон бусад ойр байсан хүмүүсийн талаарх мэдээллийг эмнэлгийн мэргэжилтэнд өгөх үүрэгтэй
- Тогтоосон эмчилгээний дэглэмийг дагаж мөрдөх үүрэгтэй.



Сүрьеэтэй өвчтөний үүрэг

Сүрьеэтэй өвчтөний үүрэг

- Эрүүл мэндийнхээ тухай эмнэлгийн мэргэжилтэнд мэдээлэл өгөх үүрэгтэй
- Өвчтөнтэй ойр байсан гэр бүлийн гишүүд, ойр дотны болон бусад ойр байсан хүмүүсийн талаарх мэдээллийг эмнэлгийн мэргэжилтэнд өгөх үүрэгтэй
- Тогтоосон эмчилгээний дэглэмийг дагаж мөрдөх үүрэгтэй.



1. Зураг үзүүлж “Та сүрьеэтэй өвчтөний үүргийн талаар мэдэх үү?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

“Сүрьеэтэй өвчтөн дараах үүрэгтэй:

- Эмнэлгийн ажилтанд өөрийн эрүүл мэндийн одоогийн байдал, өнгөрсөн хугацаанд өвдөж байсан өвчин, харшлын урвал болон бусад ямар нэгэн мэдээллийг бүрэн дүүрэн өгөх үүрэгтэй.
- Эмнэлгийн ажилтанд өөртэй нь ойр байсан гэр бүлийн гишүүд, ойр дотны найз нөхөд, бусад ойр байсан хүмүүсийн талаар мэдээлэл өгөх үүрэгтэй
- Өөрийн болон эргэн тойрны хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс харилцан зөвшилцөж тодорхойлсон эмчилгээний дэглэм болон эмчийн заавар, зөвлөгөөг ухамсартайгаар дагаж мөрдөх үүрэгтэй.”

24

СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХЭД Таны оруулах хувь нэмэр

**Сүрьеэгээс
бүрэн эдгэрэх нь
сүрьеэтэй тэмцэхэд
оруулж буй таны
хувь нэмэр юм.**



Сүрьеэтэй тэмцэхэд Таны оруулах хувь нэмэр

**СҮРЬЕЭТЭЙ
тэмцэхэд Таны
оруулах хувь
нэмэр**

Сүрьеэгээс
бүрэн эдгэрэх нь
сүрьеэтэй тэмцэхэд
оруулж буй таны
хувь нэмэр юм.



1. Зураг үзүүлж “Сүрьеэтэй тэмцэхэд Та ямар хувь нэмэр оруулж чадах вэ?” гэж асуугаарай:

2. Хариултыг сонсоорой...

3. Тайлбарлаарай:

- “Та өвдсөн хэдий ч эмчилгээгээ эхэлж, эмчийн зааврыг биелүүлж байгаа бол та аль хэдийнэ сүрьеэтэй тэмцэх үйлсэд нэгджээ. Учир нь эмчилгээний үр дүнд та өөрөө эрүүл болохын зэрэгцээ орчин тойрондоо халдвар тараах аюулгүй болж, хамгийн багадаа 10-12 хүнийг халдвар авахаас сэргийлж байгаа юм.

Сүрьеэгээс бүрэн эдгэрснийхээ дараа та амьдралдаа дахин нэг ялалт байгууллаа гэж хэлэх болно, яагаад гэвэл та өөрийнхөө хичээл зүтгэл болон эмнэлгийн ажилтнуудын дэмжлэг, тусламжтайгаар сүрьеэг бүрэн эдгээлээ. Энэ бол сүрьеэтэй тэмцэхэд таны оруулах хувь нэмэр юм.”

25

БАЙНГА АСУУДАГ АСУУЛТУУД

- ? Сүрьеэ удамшдаг уу?
- ? Гэр бүл зохиоход сүрьеэ саад болох уу?
- ? Хэрэв жирэмсэн болон хөхүүл эх сүрьеэгээр өвдвөл яах вэ?
- ? Хэрэв сүрьеэтэй гэдгээ нуувал юу тохиолдож болох вэ?
- ? Сүрьеэ эдгэрдэг өвчин биш гэх юм?



Сүрьеэтэй тэмцэхэд Таны оруулах хувь нэмэр

БАЙНГА АСУУДАГ АСУУЛТУУД

- ? Сүрьеэ удамшдаг уу?
- ? Гэр бүл зохиоход сүрьеэ саад болох уу?
- ? Хэрэв жирэмсэн болон хөхүүлэх сүрьеэгээр өвдвөл яах вэ?
- ? Хэрэв сүрьеэтэй гэдгээ нуувал юү тохиолдож болох вэ?
- ? Сүрьеэ эдгэрдэг өвчин биш гэх юм?



- Сүрьеэ удамшдаг уу? - Үгүй, удамшдаггүй. Халдварт өвчин учир нэгэн гэр бүлийн гишүүд өвчинд өртөж болох тул удамшдаг юм шиг буруу сэтгэгдэл төрүүлдэг .
- Гэр бүл зохиоход сүрьеэ саад болох уу? - Зөвхөн эмчилгээ хийлгээгүй өвчтөнүүд хайртай хүндээ халдвар тараах аюултай байдаг. Хэрэв өвчтөн эмчлүүлсэн бол түүнийг эрүүл гэр бүл зохиоход юү ч саад болохгүй.
- Хэрэв жирэмсэн болон хөхүүлэх сүрьеэгээр өвдвөл яах вэ? - Сүрьеэгээр өвдсөн жирэмсэн эмэгтэйчүүд бусад сүрьеэтэй хүмүүсийн нэгэн адил эмчлүүлнэ. Хэрэв өвчтөн хөхүүл хүүхэдтэй бол хөхөө хөхүүлэхийг үргэлжлүүлэх ёстой бөгөөд хөхөөр хооллохыг таслах нь хүүхдийн өсөлт хөгжилд ноцтой аюул учрах болно.
- Хэрэв сүрьеэтэй гэдгээ нуувал юү тохиолдох вэ? -Сүрьеэтэй гэдгээ нууж, эмчлүүлэхгүй бол сүрьеэ эмчлэгдэхгүй. Өвчтөн ойр орчмын хүмүүст , хамгийн түрүүнд өөрийн дотны хүмүүстээ аюул занал учруулдаг.
- Сүрьеэг эдгэрдэггүй өвчин гэх юм? - Энэ бол буруу ойлголт . Өвчнийг цаг тухайд нь илрүүлж, чанартай эмийг зөв зохистой ууж хэрэглэвэл сүрьеэ бүрэн эдгэрдэг !

26